

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 1 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор сум, багийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар Төрийн албаны тухай хууль, төрийн албаны тухай хуультай холбогдон батлагдсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлэх, анхаарах асуудал, Сумд агентлагуудын ажлын уялдаа, Сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд анхаарах асуудлууд, Баримт бичгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах нь зэрэг сэдвүүдээр илтгэл, танилцуулга хийгдэж, туршлагаа хуваалцлаа. Тус сургалтын үеэр жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг сагсан бөмбөг, волейболын нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулж, багийн дүнгээр Сүмбэр сумын ЗДТГ-ын баг тамирчид тэргүүн байранд шалгарч шилжин явах цомын эзэд боллоо.

2020 оны 2 дугаар ээлжийн хугацаат цэрэг татлага 10 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд Зэвсэгт хүчний жанжин штабаас өгсөн тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн.

Дэлхийн багш нарын баярын 26 дахь өдөр, Монголын багш нарын баярын 54 дэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, Боловсролын тэргүүний ажилтан, Боловсрол, шинжлэх ухааны яамны жуух бичиг, аймгийн Засаг даргын жуух бичиг, Сүмбэр сумын Засаг даргын жуух бичиг, өргөмжлөл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Говьсүмбэрийн төлөө” зэрэг шагналуудаар нийт 73 багшийг шагнаж урамшууллаа. 2020 оны элсэлтийн ерөнхий шалгалтаар аймгийн дундаж оноо өмнөх оныхоос 8.1 функтээр ахиж, улсад 10 дугаар байраа бататгасан амжилт гаргасан. Мөн Боловсролын салбарын хөрөнгө оруулалтууд жил бүр нэмэгдэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эх соёл-Их үндэс”, Япон улсын хөрөнгө оруулалт бүхий “Өвсний үндэс”, “Монгол хүмүн-Монгол соёл” зэрэг төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж, 2017 онд 233.5 сая, 2018 онд 700.7 сая, 2019 онд 6.7 тэрбум болж өссөн. Шинээр 640 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 300 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга баригдаж, цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт нэмэгдэж, ерөнхий боловсролын сургуулиудад 23 кабинеттай болж, компьютер, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдсан.

Улсын болон Аймгийн Онцгой комиссоос 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр өгөгдсөн үүргийн дагуу Сүмбэр алт ХХК-ний зочид буудалд БНХАУ-аас ирсэн 30 монгол иргэнийг тусгаарлан ажиглах байрыг бэлтгүүлж 9 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авсан ба холбогдох хяналтыг хэрэгжүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллав.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

10 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 3962141.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс 4216292,0 мян.төг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

Улсын төвлөрсөн төсөвт 791860.0 мян төгрөг төвлөрүүлэхээс 179860.0 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар татвар төлөгч ХК-1, ХХК-319, ББН-5, ЗБН-9, Хоршоо-28, ОНӨҮГ-6, Салбар-74, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, ТББ-95, Шашны байгууллага-5, Сан-10, ОНБ-15 бүртгэгдэн, нийт хуулийн этгээд 625 болж, 4.6 хувиар нэмэгдсэн.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 6733.0 мянган төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 7669.7 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 613.4

мянган төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Статистикийн чиглэлээр: 10 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, хэвлэмэл байдлаар 135, цахимаар 450 иргэнд хүргэсэн. Мөн хүн ам, хөдөө аж ахуйн, аж үйлдвэрийн сүүлийн 5 жилийн харьцуулсан инфографикийг цахимд байршуулсан.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр: Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 7524.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 5084.3 мянган төгрөгт зөвлөмж, 2367.8 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар акт тогтоосон. 3 дугаар цэцэрлэгт 1442.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 454.7 мянган төгрөгт нөхөн төлбөрийн акт тогтоосон.

Нийгмийн даатгалын сангаас олгосон :Тэтгэвэр

№	Төрөл	2019.10.25		2020.10.25		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	
1	Өндөр настан	1731	5845453.5	1837	8049911.6	106
2	Тахир дутуу	367	837538.3	334	1199008.9	33
3	Тэжээгчээ алдсан	129	308720.2	131	407044.3	2
4	Үйлдвэрийн осол	27	258467.1	27	137570.8	
	Нийт дүн	2254	7250179.1	2329	9793535.6	75

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2019.10.25		2020.10.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян, төг/
1	ХЧТА тэтгэмж	1348	174341.2	1137	155407.1
2	ЖБА тэтгэмж	328	510341.5	331	558035.1
3	Оршуулга	60	60000.0	60	60000.0
4	ҮОМШӨ-ХЧТА	11	4777.9	7	6306.0
5	Ажилгүйдэл	182	314392.6	164	346461.0
	Нийт дүн	1929	1063853.2	1699	1156209.2

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2019.10.25	2020.10.25
Шинээр	240	325
Мөнгө тушаасан	645	504
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	213913.5	108357.5

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр: Тайлант сард “Хуулийн цаг” нэвтрүүлгийг Шүүхийн Тамгын газар, аймгийн Прокурорын газар хуваарийн дагуу бэлтгэн иргэдэд орон нутгийн телевизээр болон аймгийн цахим хуудсаар хүргэсэн.

2020 оны 10 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 30 хүнийг хамруулж, сертификат олгосон.

2020 оны 10 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд Монголын хуульчдын холбоотой хамтран Хуульчийн мэргэшүүлэх сургалт зохион байгуулж, 27 хуульч хамрагдсан.

Архивын ажлын чиглэлээр: Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2307 заалт, 10477 хүний нэр, 2521 байгууллагын нэр, 6518 газар зүйн нэр, 3018 хуудас

баримтыг программд холбож, 2374 хуудас баримтыг засварлан, 2110 хуудас баримтыг скайнердаж цахим архив үүсгэсэн.

Архивын баримтаас 14 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр нийт 574 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

- Шинээр гадаад паспорт захиалсан -2
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -43
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 25
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо – 6
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо -9
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн иргэн -10

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 3
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 48
- Гэрээний бүртгэл -40
- Барьцааны гэрээний бүртгэл-186
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -3

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -14
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 73
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 0
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар -108

Цагдаагийн хэлтэс нь: Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл урд оны мөн үеэс 17-оор буюу 43.5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 15-аар буюу 20.5 хувиар, нийт гомдол мэдээлэл 32-оор буюу 40 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

"Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл", "Мал мах", "Сүүдэр бүү тусга" "Нөхөн сэргээлт 2020", "Бодис 2020" нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажилласан. "Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл" нэгдсэн арга хэмжээний хүрээнд зам тээврийн осол хэргийг бууруулах зорилгоор алба хаагчид 24 цагаар хяналт шалгалт хийж, транзит тээврийн хэрэгсэл аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх үеийн 6 удаагийн хамгаалалтыг зохион байгуулж ажиллав.

"Сүүдэр бүү тусга" арга хэмжээний хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, Төмөр замын Чойр зангилааны ажилчдад "Цахим донтолт" сэдвээр болон "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", "Хүүхэд хамгааллын тухай хууль"-иар тус тус сургалт зохион байгууллаа.

Улсын хэмжээнд зохион байгуулж буй "Мал мах" нэгдсэн арга хэмжээний хүрээнд байнгын 1, явуулын 2 постыг гаргаж, 744 тээврийн хэрэгслийн ачаа тээшинд үзлэг шалгалт хийж, 1630 хүнийг Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах АСАП сантай тулгалт хийж, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийлээ.

Сүмбэр, Шивээговь сумдын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх, байгууллага, аж ахуйн нэгжийн хяналтын камерын хэвийн ажиллагаа, харуул хамгаалалтыг 2020 оны 10 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд шалгаж, зөвлөмж, зааварчилга өглөө. Мөн Шивээговь сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн тэсэрч дэлбэрэх бодисын хадгалалт хамгаалалтанд шалгалт хийлээ. Шалгалтын мөрөөр байгууллага, аж ахуйн нэгжийн хяналтын камерын хүчин чадлыг нэмэгдүүлэх, нийтлэг зөрчлийг арилгах чиглэлээр Цагдаагийн хэлтсийн мэдэгдлийг хүргүүлэн ажилласан.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 23 удаа ажилласнаас хулгайлах гэмт хэрэг 1, хүний амь нас эрсэдсэн 7, зам тээврийн ослын 6, бусад хэргийн газрын үзлэгт 9 удаа оролцсон. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 742 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги: Хүмүүжигч нарт мэргэжил олгох зорилгоор Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежтой хамтран Уул уурхайн хүнд машин механизмын операторчин, Зам, барилгын ажлын операторчин, Гагнуурчин мэргэжлээр 45 хүмүүжигч, хөдөлмөр хамгаалалын сургалтад 5 хүмүүжигчийг сургаж байна. Мөн согтууруулах ундаа хэрэглэн гэмт хэрэг үйлдсэн архины хамааралтай 15 хүмүүжигч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 4 хүмүүжигчийг албадан сургалтанд хамруулж байна.

Тайлант сард төлбөрийн 238 гүйцэтгэх баримт бичгээс 110 гүйцэтгэх баримт бичгийн 3043734.2 мянган төгрөг, 28 хүүхдийн тэтгэлгийн баримт бичгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 46.8 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар нь: Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө болон цаг үеийн нөхцөл байдал, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу 12 чиглэлээр төлөвлөгөөт шалгалт 3, төлөвлөгөөт бус шалгалт 1, урьдчилан сэргийлэх шалгалтыг 33 объектод, зөвлөн туслах үйлчилгээ 1, тандалт судалгаа 2, гүйцэтгэлийн шалгалт 14 удаа тус тус хийж улсын байцаагчийн дүгнэлт 10, албан шаардлага 16, хяналт шалгалтын удирдамж 11-ийг шалгалтад хамрагдсан аж ахуй нэгж байгууллагуудад хүргэж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Төлөвлөгөөт шалгалтад хамрагдаагүй ундны усны эх үүсвэрийн худаг, ус түгээх цэг, хэрэглэгчийн цэг, малчдын худаг, булаг нийт 22 газрын 37 усны дээжийг шинжилгээнд хамруулсан бөгөөд шинжилгээний дүнгээр ус хангамжийн эх үүсвэрийн 2 буюу 5.4 хувь нь хлорид 1-1.3 дахин их, 1 буюу 3 хувь нь хатуулаг зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.2 дахин, магнийн агууламж 2 эх үүсвэр буюу 5.4 хувьд 1-1.5 дахин их, фтор 2 буюу 5.4 хувьд нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.5-аар бага тодорхойлогдсон, мөн малчдын худгийн усанд фторын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.6-аар бага, 40 хувьд нь нянгийн тоо стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.1-1.3 дахин их, хэрэглэгчийн 1 цэгийн усанд төмрийн агууламж 6 дахин их тодорхойлогдсон. Шинжилгээний дүнд үндэслэн 4 газарт дүгнэлт гарган хүргүүлэв.

Мөн төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж нь шаардлага хангаагүй, эрүүл ахуйн бүс тогтоогоогүй 2 газарт албан шаардлага хүргүүлэв.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Аймгийн хэмжээний сургууль цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг шинэчлэн гаргасан бөгөөд судалгаанд 62 хүүхэд хамрагдсанаас цэцэрлэг, сургуульд 48 сурагч, сургууль цэцэрлэгт хамрагдах боломжгүй 14 хүүхдэд гэрээр хичээл зааж байна.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дэргэдэх “Үнэлгээний шинжээчийн баг”-тай хамтран, сургуулийн шинжээчийн багийг чадавхжуулах сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Сургалтын үр дүнд сургуулийн хөндлөнгийн үнэлгээг төлөвлөх, блюпринт зохиох, даалгаврын шинжилгээ хийх онол арга зүйн мэдлэгийг дээшлүүлж, 46 шинжээч багшийг бэлтгэлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн багш сургалтыг зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Аймгийн “Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийн хүрээнд “Залуучууд бидний оролцоо” өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгт салбар бүрийн төлөөлөл болж 85 залуу оролцсон.

Эрсдэлийн программд бүртгэлтэй 268 хүүхдийн гэр бүлд нарийвчилсан нөхцөл байдлын үнэлгээ хийж, 18 насанд хүрсэн 22 хүүхдийг программаас хасч эрсдэлтэй үнэлэгдсэн 65 хүүхдийг шинээр бүртгэн ажиллаж байна.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “СҮҮДЭР БҮҮ ТУСГА” сарын аяныг зохион байгуулсан. Энэхүү аяны хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн 56 албан байгууллага, аж ахуй нэгжид “Хүүхдийн ертөнцийг хайрлая, хамгаалъя” уриалгыг хүргэсэн.

Боловсролын байгууллагын 98 албан хаагчид боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгаалал, хүүхэд хамгааллын бодлого түүний хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч “Стресс уур бухимдал, түүнийг тайлах аргууд” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Мөн дунд, ахлах ангийн сурагчид болон политехник коллежийн 1 дүгээр курсын оюутнуудад “Үерхэл нөхөрлөл, бэлгийн боловсрол” сургалт зохион байгуулсан. Сургалтад 369 оюутан, сурагч хамрагдсан.

Ахлах ангийн 272 сурагчид “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ” бүлгийн сургалт, 53 хүүхдэд ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан.

Өрх гэр бүлийн сайн сайхны төлөө, тэдний харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор аймгийн Татварын хэлтэс, Шүүхийн Тамгын газрын албан хаагчдад Гэр бүлийн харилцаа сургалтыг зохион байгуулсан.

“Гэр бүлийн баяр хөөр-Хамтын аялал” сургагч багш бэлтгэх сургалтыг үндэсний 2020 оны 10 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш болон сайн дурын сургагч багш, нийт 30 хүнийг хамруулав.

Соёл, урлагийн чиглэлээр: Сүмбэр сумын ЗДТГазар болон Дуу бүжгийн Боржигин чуулгатай хамтран “Боржигин морин хуур, уртын дууны уралдаан”-ыг 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, 5 аймгийн 15 сумаас нийт 90 гаруй уртын дуучин, морин хуурчид оролцсон. Үүнээс 2 дугаар шатны шалгаруулалтанд 5 аймгийн 11 сумын 43 ардын авъяастан оролцож ур чадвар авьяас билэгээ сорьсон.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Монголын хөнгөн атлетикийн холбоо байгуулагдсаны 60 жилийн ойн нэрэмжит “ХИЛЧДИЙН БАХАРХАЛ” ахмад тамирчдын дунд зохион байгуулагдсан тэмцээнд аймгийн ахмад настнууд оролцож, 2 алт, 2 мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.

С.Балжиннямын нэрэмжит жүдо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2020 оны 10 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 4 багийн 130 гаруй тамирчид 23 жинд өрсөлдөж, түрүүлсэн тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авсан.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2019 оны 10 сар	2020 оны 10 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	370	345
Гэрийн төрөлт	0	0
Амьд төрсөн хүүхэд	372	349
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	51	62
Эмнэлгийн нас баралт	10	2
Хоног болоогүй нас баралт	3	0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	4	2
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
Эмнэлгээс гарсан хүний тоо	4007	3444

Амбулаторийн үзлэг	79280	74068
Халдварт өвчин	141	65

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эмч эмнэлгийн мэргэжилтний чадавхийг дээшлүүлэх ажлын хүрээнд лавлагаа шатны эмнэлгээс төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг томилж 14 хоногоос 1 сарын хугацаатай ажлын байрны сургалтыг зохион байгуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн газар, Боржигин өв музей, Хүнс, хөдөө аж ахуйн газар зэрэг 3 байгууллагад 7 ахмад мэргэжилтэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, хамтран ажиллаж байна.

Аж ахуй нэгж байгууллагаас 57 сул ажлын байрны захиалгыг авч, 71 иргэнд ажлын байр санал болгож, 38 иргэнийг ажилд зуучилсан байна. Нийт 25 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх ганцаарчилсан үйлчилгээг үзүүлж, ажил хайгчаар бүртгэж, тохирох ажлыг санал болгосон. Үүнд: Ажил олоход хүндрэлтэй, ажил хайгч- 9 иргэн, Их дээд сургууль коллеж төгсөгч-3 иргэн, цэргээс халагдаад ажилгүй байгаа - 13 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, ажлын байрыг дэмжих 5 хөтөлбөр, ажлын зарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөөг өгч, гарын авлагаар хангасан.

Ахмад настуудад үзүүлэх хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээнд 839 иргэн хамрагдаж 78.548.300 төгрөг зарцуулсан.

“Ахмад настны өдрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх аж ахуй нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах” ажлыг зохион байгуулан аймгийн Ахмадын хороотой 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр “Өдрийн үйлчилгээ” үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр: Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, аймаг дундын Малх отрын бүсийн орон тооны бус зөвлөлийн ээлжит хурлыг 2020 оны 10 дугаар сарын 8-ны өдөр манай аймагт зохион байгууллаа. Хурлаар аймаг дундын Малх отрын бүсэд мал өөрийн сумдын 89.0 мян.толгой, Өвөрхангай, Дундговь аймгуудын 44.0 мянган толгой малыг өвөлжүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/320 дугаар захирамжаар “Отрын бүсэд орох, дамжин өнгөрөх маршрут”-ыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Бэлчээрийн гарц 9 дүгээр сарын сүүлээр жигд сайн байгаа ч өвөлд хадгалагдах ургамал нь ховор, бэлчээрийн хүрэлцээ хангамж 73.8 хувьтай байна. Манай аймагт сүүлийн 3 жилд өвөлжсөн цагаан зээрийн тоо толгойн дундаж 150.0 мян.толгой, тусгай хамгаалалттай газрын аргаль дунджаар 315 толгой гэх мэт тооцоолж, аймгийн дүнгээр хонин толгойд шилжүүлснээр 645.0 мян.тол мал өвөлжиж, хаваржихаар байна.

Аймгийн дүнгээр 7810 га хадлангийн талбайтай ч байгалийн хадлан бэлтгэх боломжгүй байна. Хадлангийн 6 салаа, 3 иргэн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Дорнод аймгийн Булган, Халх гол, Хөлөнбуйр сумдаас нийт 2500 га талбайн зөвшөөрөл авч, 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 1626 тн өвс хадсан мэдээтэй байна. Аймгийн дүнгээр малчын өрхүүд 1195 тн өвс, 36 тн үйлдвэрийн тэжээл, 23 тн гар тэжээл, 56 тн хужир шүү бэлтгээд байна.

Үйлдвэр, худалдаа үйлчилгээ: Ахуй үйлчилгээг хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ахуй үйлчилгээ эрхлэгчдэд мэдээлэл өгөх, хамтран ажиллах, цаашдын үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор ахуй үйлчилгээний байранд үйл ажиллагаа явуулж буй 12 иргэнийг сургалтад хамруулав. Сургалтын үеэр цаашид хамтын ажиллагаатай байх, аливаа арга хэмжээнд оролцоотой байх талаар хэлэлцэв.

Орон нутгийн Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор Сүмбэр, Шивээговь, Баянтал суманд бүтээгдэхүүн үйлчилгээг тодорхой хугацаагаар тогтоосон цэгт борлуулах боломжийг бүрдүүлж, сум тус бүр дотоод үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний брендийг тодруулах, шалгаруулах зорилгоор үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 55 иргэн, ААН-нэгжийн төлөөлөл 20 гаруй төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 25.4 сая.төгрөгийн

борлуулалт хийсэн байна. Үзэсгэлэн худалдаанд оролцсон газар тариалангийн бүтээгдэхүүнийг 100 хувь шинжилгээнд хамруулж баталгаажуулсан.

Үндэсний уламжлалт хоол, идээ ундааг сурталчлах зорилгоор үндэсний хоолны цахим хичээлийг байгууллагын цахим хуудас болон нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 5 газарт заалны дэлгэцээр иргэдэд сурталчилан хүргэж байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2020 оны 10 дугаар сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай, цул/ махны үнэ 1000-1500 төгрөгөөр, хонины мах /ястай,цул/ 1500 төгрөгөөр, адууны мах /ястай, цул/ 1000-1500 төгрөгөөр, ямааны мах /цул/ 1200-1500 төгрөгөөр, төмс 200 төгрөгөөр зарим хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 200-300 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан	
1	Үхрийн мах	Ястай	8000	7500	-1500
		Цул	10000	9000	-1000
2	Хонины мах	Ястай	7500	5500	-1500
		Цул	9000	8000	-1500
3	Адууны мах	Ястай	6500	5500	-1000
		Цул	8000	6000	-1500
4	Ямааны мах	Ястай	5500	5000	-1200
		Цул	8000	6000	-1500
5	Тахианы мах	Гуя	10500	7900	
		мөч	8000	7900	
6	Лууван	монгол	1500	1200	-300
		хятад			
7	төмс	монгол	800	700	-200
		хятад			
8	Байцаа	монгол	800	600	-200
		хятад			-
9	чинжүү	монгол	7500	7000	-
		хятад	6500	4500	
10	Манжин	монгол	2000	1500	
		хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	2800	1800	-
		Хятад	1500	1400	-
12	Улаан лооль	монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	монгол	7500	6500	-
14	Элсэн чихэр	монгол	2200	1600	-
15	Будаа	Цагаан задгай кг	2500	2200	
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	2500	2000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
17	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	750	-
19	Өндөг	ОХУ	400	360	-
		Монгол	400	330	-

20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1140	1100	+20
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан /д.дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлын тос	Олейна	5500	4800	+50
		Алтан	3800	3600	-
22	Гоймон	Алейка	1800	1600	-
		А/тариа савхан	1100	950	-

2020 онд 17.9 га-д төмс, 21.5 га-д хүнсний ногоо, 10 га-д тэжээлийн ургамал нийт 49.4 га талбайд тариалалт хийсэн. Цаг агаарын хүндрэл бэрхшээлээс болж төмсний 0.23 га, хүнсний ногооны 2.5 га талбайн ургац алдсан. 10 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар 16.7 га-аас 140 тн төмс, 18.7 га-аас 132.1 тн хүнсний ногоо хураан аваад байна. Ургац хураалт 96 хувь, үүнээс төмсний хураалт 94 хувь, хүнсний ногооны хураалт 98 хувьтай байна.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Аялал жуулчлалын төрөлжсөн сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зорилтот бүлэгт чиглэн зохион байгууллаа. Тус сургалт нь онол практик хосолсон байдлаар зохион байгуулагддаг бөгөөд аймгийн хэмжээнд 62 иргэн хамрагдсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон дахивар хаягдал нягтруулан шахах төхөөрөмжийг 2020 оны 10 дугаар сарын 7-ны өдөр “Сан-Оргиу” ХХК хүлээлгэн өгч, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавар журмыг танилцуулан, 100 кг хаягдал хуванцар савыг нягтруулан шахаж туршилт хийлээ.

“Тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа”-г зохион байгуулж, аймгийн хэмжээнд 10 гаруй аж ахуйн нэгж байгууллагын 200 гаруй албан хаагч, 50 иргэн 3755 ширхэг мод буцыг тарьсан байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний ажлын хүрээнд: 10 дугаар сард Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс 8 хугацааны мэдээ, нийт 248, климат агро дундаж мэдээ, Хөдөө, аж ахуйн тойм, 10 хоногийн тойм мэдээг 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

Тайлант сард азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 36 удаа хийж, азотын давхар исэл (NO₂) 0.017 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.018 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Аймгийн Засаг даргын захирамжаар газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн нэгж талбарын хувийн хэргийг нийт 92 нэгж талбарын хувийн хэргийг зориулалт тус бүрээр цахим архив үүсгэн ажиллаж байна.

Газрын кадастрын мэдээллийн санд Шивээговь сумын газрын даамал нь өвөлжөө, хаваржааны зориулалтаар 58 нэгж талбар, иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 4 нэгж талбар, авто гаражын зориулалтаар 6 нэгж талбар, нийт 68 нэгж талбарыг нөхөн оруулаад байна. Мөн өвөлжөө, хаваржааны зориулалтаар олгогдсон газруудын талбайн солбилцол авч мэдээллийн санд оруулан ажилласан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 80 хувьтай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга угсралтын ажил 35 хувьтай, Сүмбэр сум 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавих ажил 85 хувьтай тус тус хийгдэж байгаа бөгөөд 2021 онд үргэлжлэн хийгдэнэ.

Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил 90 хувьтай, Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 60 хувьтай хийгдэж байгаа бөгөөд Чойрын хийдийн гол Дуганы барилгад улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан, 2019-2020 онд дамжин хэрэгжиж байгаа 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгад дотоод хяналтын комисс ажиллаж, үүрэг даалгавар өгсөн.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж буй Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 85 хувьтай хийгдэж байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Найрамдал хотхоны өргөх станцын барилгын ажил улсын комисс ажиллуулах шатанд, Сүмбэр сумын 2, 3 дугаар багт тоглоомын талбай байгуулах ажил, Сүмбэр сумын 3 дугаар багийн тоглоомын талбайн ажлуудад улсын комисс ажиллуулж, ашиглалтад хүлээн авсан.

Тээвэр, авто замын талаар:Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 425 тээврийн хэрэгсэл хамрагдсан бөгөөд 2020 оны өссөн дүнгээр 5917 тээврийн хэрэгсэл хамрагдсан байна.

Тайлант хугацаанд хот хооронд 631 иргэн зорчиж, 61 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн, ачаа тээвэрлэлтийн 300 замын хуудас олгосон байна.

Худалдан авах ажиллагааны талаар: 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр 9 ажил хийхээр төлөвлөсөн. 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 7 ажлын тендер шалгаруулалтыг зарласнаас 5 бараа ажил үйлчилгээний ажил дуусч ашиглалтад хүлээн авсан, 1 ажил хийгдэж байгаа, 1 бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээ хийгдэж, 1 тендер шалгаруулалтыг дахин зарлахаар бэлтгэж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 20 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 20 ажлын тендер шалгаруулалт зарлаж, 12 бараа ажил үйлчилгээний ажил дуусч ашиглалтад хүлээн авсан, 7 бараа, ажил, үйлчилгээний ажил хийгдэж байна, 1 ажлын тендер шалгаруулалтыг зарласан. Авто замын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 5 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг 100 хувь гүйцэтгүүлсэн байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Сүмбэр сум: Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн А байрыг ашиглалтанд бүрэн хүлээж авч, цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн бөгөөд бага бүлгийн 43, ахлах бүлгийн 34, бэлтгэл бүлгийн 34 хүүхдийг хүлээн аваад байна.

Давхардсан тоогоор нийт 48 нярайг эхийн хамт, 64 ахмад настанг гэрийн эргэлтээр эргэж шаардлагтай анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан бөгөөд 14 хоногийн товлолт дархлаажуулалтанд нийт 135 хүүхэд, Томуугийн вакцинд 400 ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эх, 200 сайн дурын иргэн, 60 эрүүл мэндийн салбарын ажилчид, 0-5 насны 889 хүүхэд тус тус хамрагдсан .

10 дугаар сарын 8-ны өдөр нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, 67 байгууллага 15 тонн хог хаягдлыг, 228 өрх 41 тонн хог хаягдлыг тус тус цэвэрлэсэн.

Бүх нийтээр мод тарих өдөр сумын харьяа аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 350 ш мод тарьсан байна.

Орон сууц, гэр хороолол болон нийтийн эзэмшлийн гудамж талбайн 110ш гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааг ханган шинээр сольж, 10 сард 1 удаа цас орсныг давс цацаж аюулгүй байдлыг хангасан бөгөөд 12 тн давс, бодис нөөцөлсөн.

REW-1 вакцинд 371 малчин өрхийн 58573 хурга, 44667 толгой ишиг, нийт 103240 төл мал хамрагдсан нь 94.1 хувьтай байна.

Штам-19 вакцинд 190 малчин өрхийн 2497 тугал хамрагдаж, тарилгын явц 82.4 хувьтай байна.

Мялзангийн вакцинд нийт 201 малчин өрхийн 63618 төл мал хамрагдсан бөгөөд тарилгын явц 58 хувьтай байна.

Мал аж ахуйн намрын технологит ажил эхэлсэнтэй хобогдуулан ангилалт хянан баталгаажуулалт, бог малын хээлтүүлэгчийг эх сүргээс нь тусгайлан ялгасан сууриудад хяналтын хэмжилт хийж гэрээ дүгнэх ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар 1326 хуц, ухна хамрагдсан нь 65.6 хувьтай байна.

Шивээговь сум: Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн нээлтийн үйл ажиллагааг 2020 оны 10 сарын 1-ний өдөр зохион байгуулж, 5 байгууллагын 7 албан хаагч, 100 гаруй нэр төрлийн үйлчилгээг нэг дороос иргэдэд үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. 2020 оны 10 сарын 25-ны өдрийн байдлаар төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 400 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартын анхдагч баталгаажуулалтын аудитыг 2020 оны 10 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд хийлгэж, 10 дугаар сарын 12-ны өдөр гэрчилгээ гардан авсан.

Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө 89 хувийн хэрэгжилттэй байна. Сумын Засаг даргын албан даалгаврыг 71 малчин өрхөд хүргүүлж, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хашаа хорооны хөрзөн хуулах, мал амьтны хашаа хорооны 48746м² талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийсэн байна. Малчид өөрсдийн хүчээр 173.37 тн өвс, 10 тн тэжээл, 7 тн гар тэжээл бэлтгэсэн байна.

Дундговь аймгийн Эрдэнэдалай, Луус, Адаацаг, Дэлгэрхангай сумдаас 7 малчин өрхийн бог 4400, бод 670, нийт 5070 толгой мал тарилга туулгалтанд хамрагдаагүй, гарал үүслийн бичиггүй отроор ирснийг мэдэгдэл хүргэн яаралтай нүүлгэх арга хэмжээг аваад байна.

Мал эмнэлгийн нэгж нь дуут хавдар, сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 24 өрхийн 781 малд хийж, ямлуур, сүрээ өвчнөөс урьдчилан сэргийлэх оношлуурыг 22 өрхийн 400 малд тарьсан. Шүлхий, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс тарьж 10 хувийн гүйцэтгэлтэй байна.

Баянтал сум: 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр сумын төв талбай дээр “Дэлхийн алхалтын өдөр”-ийг тохиолдуулан төрийн бус байгууллага, ард иргэдийн дунд явган алхалт болон тэмцээн уралдааныг зохион байгуулсан.

Бэлчээр чөлөөлөх шаардлагатай отрын 10 өрх айлд албан шаардлага хүргүүлсэн. Мөн сумын малчидтай уулзалт зохион байгуулж, өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцсан.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР